



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/33/25

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “АЖМХ-ны нэрэмжит аялал жуулчлалын шилдэг оюутны тэтгэлэг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.



Б.ЗОЛБАДРАЛ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ НЭРЭМЖИТ “ШИЛДЭГ ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ, ШАЛГАРУУЛАХ” ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Аялал жуулчлалын мэргэжлийг сонгон амжилттай суралцаж буй оюутнуудын нийгмийн идэвх, оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас, чадвар, хүсэл сонирхлыг урамшуулан дэмжих, мэргэжлийн ур чадварыг нь хөгжүүлэх, өндөр оноотой төгсөгчдийг тус мэргэжлээр элсүүлэх замаар шинэ элсэгчдийн чанарыг дээшлүүлэх зорилгоор сурлага, хариуцлага, манлайлал, мэргэжлийн өсөлт, хүсэл эрмэлзэлтэй шилдэг оюутныг шалгаруулах, тэтгэлэг олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь хоёр дахь дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа, бакалаврын хөтөлбөрт эчнээ, орой хэлбэрээр суралцаж буй суралцагчид, гадаад улсаас суралцаж буй оюутан, түр болон үнэ төлбөргүй сургалтад хамрагдаж буй суралцагчдад хамаарахгүй.

Хоёр. Тэтгэлгийн төрөл, шалгаруулах үзүүлэлт

- 2.1 Тэтгэлэг нь аялал жуулчлалын чиглэлээр бакалаврын түвшний мэргэжилтэн бэлтгэж буй сургуульд амжилттай суралцаж 1.000.000.000 тэтгэлэгт дадлага хүний нөөцийн зорилтот төсөлд хамрагдан ажлын байранд дадлагажиж буй шилдэг оюутанд дэмжлэг үзүүлэхэд зориулагдах ба суралцагчийн сургалтын төлбөрийн тодорхой хэсгийг мөнгөн хэлбэрээр санхүүжүүлэхэд буцалтгүй тусламж хэлбэрээр олгогдоно.
- 2.2 Тэтгэлэг авсан оюутнууд дундаас гадаадын их сургуульд аялал жуулчлалын чиглэлээр суралцах болзлыг хангасан Шилдэг 1 оюутны сургалтын холбогдох зардлыг тэтгэлэг хэлбэрээр дахин олгож болно.
- 2.3 Аялал жуулчлалын мэргэжлээр суралцаж буй шилдэг оюутанд олгох тэтгэлэг нь Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн нэрэмжит байна.
- 2.4 “Шилдэг оюутан”-д олгох тэтгэлэгийг дараах амжилт гаргасан суралцагчдад олгоно. Үүнд: 1.000.000.000 тэтгэлэгт дадлага хүний нөөцийн зорилтот төсөлд хамрагдан 2-р шатанд шалгарсан, сурлагын дүнгийн голч оноо, эрдэм шинжилгээ, мэргэжилдээ дур сонирхолтой байдал, ур чадвар, улсын болон олон улсын уралдаан, тэмцээн, үзэсгэлэн, наадам, фестиваль, олимпиадад амжилттай оролцсон байдал, зохион байгуулсан олон нийтийн ажил, сайн үйлсийн аян, мэргэжлийн болон сайн дурын оюутны клубийн үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцсон байдал, оюутны санаачлан хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр зэргийг харгалзан дүгнэж 2-4-р курсийн шилдэг оюутнуудыг сонгон шалгаруулж олгоно.

Гурав. Шалгаруулалт

- 3.1 Салбарын шилдэг оюутанд олгох тэтгэлгийн нөхцөл, тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх, шалгаруулах, тэтгэлгийг олгох зэрэг үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 3.2 1.000.000.000 тэтгэлэгт дадлага хүний нөөцийн зорилтот төсөлд хамрагдан 2-р шатанд шалгарсан оюутнуудын материалыг Аялал жуулчлалын боловсрол, хөгждийн нийгэмлэгээс тухайн оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сонгон шалгаруулалтын комисст ирүүлнэ. Комисс 9 дүгээр сарын 20-ны дотор оюутнуудтай ярилцлага хийж шалгаруулна.
- 3.3 Сонгон шалгаруулалтын комисс материалуудыг хянаж үзсэний үндсэн дээр болзол хангасан оюутны материалыг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- 3.4 Тэтгэлэгт хамрагдах болзол хангаж шалгарсан суралцагчдад дүнг мэдээлж, мэдээллийг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэгийн цахим хуудсанд байрлуулна.
- 3.5 Оюутанд олгох тэтгэлгийн батламжийг Дэлхийн аялал жуулчлалын өдөрт зориулсан ёслолын ажиллагаа, Эрдэм шинжилгээний хурал болон бусад арга хэмжээний үеэр гардуулна.
- 3.6 Ижил төрлийн тэтгэлгийг нэг суралцагчид давхардуулж олгохгүй.

Дөрөв. Тэтгэлгийн хэлбэр, хэмжээ

- 4.1 “Шилдэг оюутан”-д олгох тэтгэлгийг 1.000.000.000 тэтгэлэгт дадлага хүний нөөцийн зорилтот төсөлд хамрагдан 2-р шатанд шалгарсан **ТОДОРХОЙЛОЛТ, СУРЛАГА** /дүнгийн голч/, **ХАРИУЦЛАГА** /олон нийтийн ажилд оролцсон байдал, сайн үйлсийн аян, өөрийн санаачилгаар хэрэгжүүлсэн төсөл, байгаль орчныг хамгаалах чиглэлд оролцсон, зохион байгуулсан ажил/, **МАНЛАЙЛАЛ** /эрдэм шинжилгээний хурал, улсын болон олон улсын уралдаан, тэмцээн, үзэсгэлэн, наадам, фестиваль, олимпиадад амжилттай оролцсон байдал/, **МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТ** /мэргэжлийн болон сайн дурын оюутны клубийн үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцсон байдал/, **ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ** /ярилцлага/ зэргийг зохих оноогоор дүгнэн олгоно. Тэтгэлгийн хэмжээ 1.000.000 төгрөгөөс доошгүй байна.
- | | | |
|---|------------------|---------|
| - | ТОДОРХОЙЛОЛТ | 30 оноо |
| - | СУРЛАГА | 4 оноо |
| - | ХАРИУЦЛАГА | 4 оноо |
| - | МАНЛАЙЛАЛ | 4 оноо |
| - | МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТ | 4 оноо |
| - | ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ | 4 оноо |
- Нийт 20 оноогоор дүгнэн шалгаруулна.
- 4.2 Тэтгэлгийн мөнгөн дүнгийн хэмжээ, олгох хугацаа, давтамж, тэтгэлэгт хамрагдах хүний тоо зэрэг нь жилд нэг удаа буюу тогтмол байна.
- 4.3 Нэг оюутанд олгох тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, шинэчлэх тохиолдолд санхүүжүүлэгч байгууллагуудтай зөвшилцөж шийдвэрлэн, баталгаажуулна.
- 4.4 Аялал жуулчлалын сургалттай сургуулиудын оюутнуудад тэгш, хүртээмжтэй байдлаар тэтгэлэг олгох зарчмыг баримтална.

Тав. Тэтгэлгийн санхүүжилтийн эх үүсвэр

- 5.1 Тэтгэлгийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс байж болно. Үүнд:
 - 5.1.1 АМЖХолбооны хүний нөөцийг дэмжих сан
 - 5.1.2 Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардал
 - 5.1.3 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
 - 5.1.4 Олон улсын байгууллагын тусламж
 - 5.1.5 Хуульд заасан бусад эх үүсвэрээс

Зургаа. Бүрдүүлэх материал

- 6.1 Шилдэг оюутны шалгаруулалтад оролцогчид дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:
 - 6.1.1 “Шилдэг оюутан” тэтгэлэгт нэр дэвшигчид маягт 1-ийн дагуу анкет, материал бүрдүүлнэ.
 - 6.1.2 Амжилтыг гэрчлэх баримт (эх хувь эсвэл баталгаажуулсан хувь)
 - 6.1.3 Цахим систем дэх дүнгийн хуудас, дүнгийн голч (баталгаажуулсан эх хувь)

Долоо. Тэтгэлгийг түдгэлзүүлэх, цуцлах

- 7.1 Оюутан улирлын болон жилийн чөлөө авсан тохиолдолд тэтгэлэг олголтыг түдгэлзүүлнэ.
- 7.2 Тэтгэлэгт хамрагдсан боловч захиргааны болон гэмт хэргийн зөрчил гаргасан, тэтгэлэгт хамрагдахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн г.м шалтгаанаар тэтгэлгийг олгох боломжгүй нь тогтоогдсон нөхцөлд тэтгэлэг олголтыг бүрмөсөн цуцална.

----oOo----

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны нэрэмжит
“шилдэг оюутны тэтгэлэг олгох, шалгаруулах”
журмын хавсралт
Маягт 1

ШИЛДЭГ ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

Зураг (3*4)	Ургийн овог:	
	Эцэг/эхийн нэр:	
	Өөрийн нэр:	
	Регистрийн дугаар:	
	Оюутны код:	
	Сургууль:	
	Хөтөлбөрийн нэр:	
	Үнэлгээний голч дүн:	

Тэтгэлгийн төрөл:

Сурлага, хөдөлмөр, урлаг спорт, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, наадам, фестиваль, олимпиад, эрдэм шинжилгээний хурал, сайн дурын аян зохион байгуулсан, оюутны санаачилгатай клуб ажиллуулсан, төсөл хөтөлбөрт оролцсон байдал (сүүлийн хичээлийн жилд)

Уралдаан тэмцээний нэр	Зэрэглэл, Чансаа	Хэзээ	Хаана	Гаргасан амжилт

Өмнө нь тэтгэлэгт хамрагдсан байдал (сүүлийн хичээлийн жилд)

Тэтгэлгийн нэр	Хэзээ	Хаана	Тэтгэлгийн хэмжээ

Холбоо барих утасны дугаар: 1..... 2.

И-мэйл хаяг:

Дээрх мэдээллийг үнэн зөв бөглөсөн:()
(Гарын үсэг)

202.... он сар өдөр

